

VI. Намтар судлал

ЕЛЮЙ ЧУЦАЙ

Н. Төмөр

Шинжлэх Ухаан Академийн Олон улс судпалын хүрээлэн.

int_stud@arvis.ac.mn

Өгүүллийн төвч утга: Елюй Чуцайн бага балчир нас, Эзэн богд Чингис хааны дэргэд шадарлан зүтгэсэн, Өгэдэй хааны үед Их Монгол Улсын төрийн албан тушаалд томилогдон хүчин зүтгэсэн тухай өгүүлэв.

Түлхүүр үг: Их Монгол Улс, Чингис хаан, Өгэдэй хаан, Елюй Чуцай

Их Монгол улсын төрийн зүтгэлтэн, Чингис хааны есөн өрлөгийн нэг "Чуу мэргэн", хятан угсааны сурвалжит Елюй овгийн хүн Елюй Чуцай 1190 онд Алтан улсын нийслэл Чжунду хотод төржээ.¹ Елюй Чуцай нь Ляо улсын хараат улс болох Дорнод Дан улсын ван Елюй Туюгийн жилийх буюу наймдугаар үеийн ач хөвгүүн бөгөөд түүний эцэг Елюй Люй нь Алтан улсын төрд баруун этгээдийн тэргүүн сайдын алба хашиж байсан.² Елюй Чуцайг З настай байхад түүний эцэг нас барсан учир тэрээр өнчрөн хоцорч, төрсөн эх Янши-гээр бичиг ном заалган, эрдэм боловсролтой болж, улмаар одон орны судлал, газар зүй, тооны ухаан, Буддийн болон Бомбын шашны сургаалыг судалж, эмчлэх төлөгдөх аргыг сурч шүлэг, ном зохиол бичдэг болжээ.³

Елюй Чуцай нь Алтан улсын нийслэл Чжунду-д төрийн алба хашиж байсан ба 1215 онд Чжунду хот Чингис хааны цэрэгт эзлэгдсэний дараа Елюй Чуцайн хувь заяанд эргэлт гарч, шар бар жил буюу 1218 онд тэрээр Чингис хаанд дуудагдан анх удаагаа хаантай уулзжээ.⁴ Үүнээс хойш Елюй Чуцай Монголын төрд хүчин зүтгэх болж, өндөр албан тушаал эзлэн Чингис, Өгэдэй нарт Монголын төрийн хэрэг явдал болоод ялангуяа эзлэгдсэн орнуудыг хэрхэн захирах талаар чухал хэрэгтэй зөвлөлгөөг гарган айлтгаж байсан бөгөөд Монголын хаад ч түүний зөвлөмж саналыг харгалздаг байсан билээ.⁵

Чингис хаан Елюй Чуцайг 1218 онд Хэрлэн мөрний хөвөөн дэх ордондоо хүлээн авч уулзсаны дараа, түүнийг өөрийн дэргэд шадар болгон байлгахаар шийджээ. Елюй Чуцай Чингис хааны дэргэд зөвлөгч, төлөгч, бичээчээр ажиллаж байгаад нэг жилийн дараа 1219 оноос Чингис хааны Дундад Азийн орнууд руу явуулсан аян дайнд биеэр оролцож, Дундад Азид 10 орчим жил ажиллаж амьдарчээ.

Елюй Чуцай Чингис хааны шадар зөвлөгчөөр хаантай хамт Хорезм улсын эсрэг хийсэн аян дайнд явж, тэрээр монголын цэрэг Хорезм руу явсан замын маршрутыг тэмдэглэн, замдаа үзэж харснаа "Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл" зохиолдоо тодорхой дүрслэн бичжээ.⁶ Монголын цэрэг нутгаасаа 1219 оны зургаан сард гарсан бөгөөд их цэрэг хөдлөхийн өмнө цэргийн тугийг тахижээ. Тахилгын ёслолыг үйлдэх яг тэр үед тэнгэр гэнэт харанхуйлан "гурван тохойн чинээ бороо цас" холилдон орсон нь⁷ муу ёр хэмээн Чингис хааны сэтгэл санааг нэлээд их зовоожээ. Тэгэхэд Елюй Чуцай дээрхи байгалийн үзэгдлийг тайлбарлан хэлэхдээ, "идэр зуны цагт бороо цастай цуг орох нь дайсан этгээдийг ялан дийлэхийн бэлэг тэмдэг" хэмээжээ.⁸ Елюй Чуцайн энэхүү тайлал нь шинжлэх ухааны ямар ч үндэслэлгүй боловч бэлэг дэмбэрэлтэй тэрхүү уг нь тухайн үед монголын цэрэгт байлдах урам зориг оруулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн учраас Чингис хаанд нэн таалагдаж, түүний сэтгэлийг нь ч засжээ.

Елюй Чуцай Алтайн уулсыг даван, Эрчис мөрөн хүрч очих замдаа ажиглан үзсэн зүйлээ, ялангуяа Алтайн уулсын байгалийн үзэсгэлэнт сайхан байдлыг дүрслэн тодорхой бичжээ.⁹ Чингис хааны цэрэг Эрчис мөрнөөс урагшаа уруудан, Була хэмээх эртний хотод¹⁰ ирээд тэндээс бас дахин урагшаа явж Борохоро

нурууг давжээ.¹¹ Елюй Чуцай Борохоро уулсын үзэсгэлэнт байгалийг "Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл" зохиолдоо нэлээд тодорхой дурслэн бичихдээ, "зүүнээс баруун тийш нэг мянган ли /ли нь уртын нэгж бөгөөд 1 ли нь 0.5 км-тэй тэнцэнэ./, хойноос өмнө тийш хоёр зуун ли үргэлжилсэн уулын орой дээр нэгэн дугуй хэлбэрт цөөрөм буй бөгөөд түүний эргийн урт нь 70-80 ли орчим. Цөөрмийн урд талд нь нарны гэрэл ч үл нэвтрэх битүү аллимны модон ойтой" хэмээжээ.¹² Дээр дурдсан цеөрмийг Елюй Чуцай мөн Толыт нуур гэж зохиолдоо тэмдэглэсэн ба энэ нь одоогийн Сайрам нуурыг хэлж буй бололтой. Борохоро нурууг давсан монголын цэрэг 1211 оноос Их Монгол улсын мэдэлд орсон Алмалык¹³ хотод хүрэлцэн иржээ. Елюй Чуцай зохиолдоо, энэ хотод янз бурийн жимс элбэг бөгөөд уг хотын 8-9 дагуул суурин газарт усан үзэм, лийрний мод ургуулан таван төрлийн буудай тариалдаг хэмээн тэмдэглэжээ.¹⁴

Чингис хаан, отгон хөвгүүн Тулуйн хамт цэргийн гол хүчийг авч Сыр-дарьяя голыг гатлан Бухар хотыг дайлахаар явжээ. Тухайн үед Бухар хот бол Дундад Азийн худалдааны нэртэй том хотуудын нэг байснаас гадна мөн лалын шашинтны мөргөлийн төв байсан билээ. 1220 оны хоёр сард Чингис хааны цэрэг Бухарыг бүслэн дайрахад уг хотыг 20 мянган цэрэг хамгаалж байлаа.¹⁵ Монголын цэрэг Бухар хотыг дервэн талаас нь бүслэн хороолж, олон зүгээс ширүүн довтолжээ. Бухар хотын захирагчид айн эмээнзээс болж хотыг орхиж, амь зулбан зугадсан боловч монголын цэрэг тэдний хойноос нэхэн гүйцэж бут цохисон ажээ. Харин хотод үлдэж хоцорсон сүм хийдийн том лам нар болон баячууд монголын цэрэгт бууж өгчээ.¹⁶

Бухар хотыг эзэлсэний дараа Чингис хаан Самарканд хотыг эзлэхээр давшиж, тэр үед Самаркандыг 110 мянган цэрэг хамгаалж байсан боловч ширүүн тулалдааны эцэст монголын цэрэг Самаркандыг эзэлжээ.¹⁷ Самаркандыг эзлэх тулалдаанд маш олон цэрэг, ард иргэд амь үрэгдсэн тухай Хятад орноос Чингис хааны зарлиг ёсоор уулзахаар Самарканд хотод хүрэлцэн ирсэн Чанчунь бомбын тэмдэглэлд "Самарканд хотод амьд үлдсэн хүн ам түрүүчийн бух хүн амын дөрөвний нэг хувь байсан", Чингис хааны шадар зөвлөгч Елюй Чуцайн зохиолд "хотын талбайн тэн хагасыг булш бунхангаар дүүргэв" хэмээн тус тус тэмдэглэн бичжээ.¹⁸

Монголын цэрэг 1220 оны хавар Самаркандыг эзэлсэний дараа Чингис хаан цэргийн хамт Самаркандад хэсэг хугацаагаар байрлаад, мөн оны зуны сүүлч намрын эхээр Нахшеб /odoogийн Карши хот/ хотын ойролцоо тал нутагт очиж байрлан Хорезм улсын бусад хот суурин газрыг эзлэх байлдааны бэлтгэл хийж байлаа.¹⁹ Харин Елюй Чуцай нь Чингис хааны зарлиг ёсоор Самаркандад үлдэж, тус хотын захирагчаар томилогдсон Елюй Ахайн туслах болжээ.²⁰ Елюй Чуцай "Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл", "Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл" зэрэг зохиолдоо, Самарканд гэдэг үг бол тэр нутгийн хэлээр "баян чинээлэг" гэсэн утгатай үг хэмээн тайлбарласан байдаг.²¹ 1220-1222 онд Елюй Чуцай Самаркандад ажиллаж амьдрахын зэрэгцээ тэр нутгийн зан заншил, аж ахуй, ахуй амьдрал, байгалийн нөөц баялаг, цаг агаарын онцлог зэргийг ажиглан судалж байлаа. Ажиглан судалсан зүйлээ "Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл" зохиолдоо тодорхой тэмдэглэн бичжээ. Тэрээр бичихдээ, "Самарканд бол баян чинээлэг газар. Гүйлгээнд нүхгүй алт, гуулин зоос хэрэглэдэг байлаа. Хотыг тойрсон хэдэн арван ли-гээр /1 ли нь 0.5 км-тэй тэнцэнэ/ үргэлжилсэн талбай бүхий жимсний цэцэрлэгтэй. Айл өрх бүр хувийн жимсний цэцэрлэгтэй, цэцэрлэг болгонд усжуулах төхөөрөмжтэй, тоор чавганы модноос гадна улиас бургас зэрэг мод ургулсан байлаа. Хулуу тарvas нь адуун толгойн чинээ том, шар будаа, шош буурцагаас бусад бүх төрлийн тариа тариалдаг байжээ. Ид зуны цагт хур бороо ордоггүй болохоор голын усаар тариалангийн талбайг усалдаг байлаа. Усан үзмээр нэн сайхан амттай дарс хийдэг байсан. Нутгийнхан цагаан өнгийг

эрхэмлэн, хар өнгийг гашуудлын өнгө гэж үздэг учир бүгдээрээ цагаан хувцас өмсдөг байв" гэжээ.²²

Елюй Чуцай Самарканадад байхдаа хятад хуанлийг тухайн нутгийн хуанлитай харьцуулан "Баруун зүгийг номхотгох цагаан морин жилийн анхдагч хуанли"-г зохиож, 1222 онд Чингис хаанд өргөн барьжээ.²³ Елюй Чуцай Самарканадад байх хугацаандаа чөлөөт цаг харьцангуй ихтэй байсан тул анд нөхдийн хамт хөдөө нутгаар явж, тэр нутгийн байгалийн үзэсгэлэнт байдлыг сонирхон, үзэж харсан зүйлүүдээ "Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл" зохиолдоо тэмдэглэн үлдээжээ.²⁴ Елюй Чуцай Самарканад хотоос холгүй орших Бухар хотод их очдог байсан болохоор Чингис хааны зарлигаар томилогдсон Бухарын захирагч зүрчид гаралтай Пуца Чижинтэй нэлээд сайн нөхөрсөг дотно харилцаа тогтоожээ. Тэрээр Бухар хотын онцлог бүхий соёл урлаг, дуу бүжиг болон үзэсгэлэнт байгалийг яруу найргийн хэлбэрээр магтан бичиж, бичсэн зүйлээ анд Пуца Чижиннд тогтмол илгээн уншуулдаг байлаа.²⁵

1222 оны намар нутаг буцахаар Чингис хаан цэргээ авч Аму-дарьяя мөрнийг гатлан, Самарканадад хүрэлцэн ирж тэндээ өвөлжсөн билээ. Чингис хаан Самарканадад байхдаа Елюй Чуцайг Тараз хот /odoogийн БНКУ-ын Джамбул хот/ руу Газар тариалангийн хэрэг эрхэлсэн түшмэлээр томилон явуулж, атар газрыг эзэмших үүрэг даалгавар өгчээ.²⁶ Чингис хаан 1224 оны зун Ирчис мөрний хөвөөнд хүрэлцэн ирж, тэндээ нэлээд удаан хугацаагаар саатаж, агт морьд, цэргээ амрааж алгуур явсаар 1225 оны хавар нутагтаа буцаж иржээ.²⁷ Тараз хотын Газар тариалангийн хэрэг эрхэлсэн түшмэлээр томилогдсон Елюй Чуцай Чингис хаантай цуг Монгол нутаг руу буцаагүй билээ. Тэрээр Тараз хотод үлдэж хааны үүрэг даалгаварыг биелүүлэн ажиллаж байгаад 1224 оны намар сая тэндээс Монгол руу буцахаар гарчээ. Елюй Чуцай Монгол руу буцаж явахдаа Алмалык хотоор дамжин 1225 оны өвөл Бешбалиг /odoogийн СҮӨЗО-ны Джимсарын нутаг дэвсгэрт оршиж байсан эртний хот/ хотод хүрэлцэн иржээ.²⁸ Елюй Чуцай Бешбалигт ирээд төдий л удаагүй байтал Чингис хаан Тангудын Сися улсын эсрэг дайтахаар шийдвэрлэжээ. Чингис хаан өөрийн биеэр их цэрэг авч Тангудын Сися улсыг дайлаар мордохдоо хөвгүүдээс Өгэдэй, Тулуй, жанжин нараас Сүбээдэй, зөвлөх нараас Буурч, эрдэмтдээс Елюй Чуцайг авч явжээ. Дээр дурдсан хүмүүс бол Чингис хааны "Сэцдийн зөвлөл"-ийн гол гишүүд байлаа.²⁹

Елюй Чуцай Чингис хааны их цэрэгтэй хамт Тангудын Сися улсын нутаг дэвсгэрт орж ирээд 1226 оны таван сарын үед Сүчжоу хотын харьяа Шаньшань хэмээх суурин газарт /odoogийн Ганьсу мужийн Цзюйциоань хот/ байрлажээ.³⁰ 1226 оны намар монголын цэрэг Ганчжоу, Шилян зэрэг хотуудыг эзэлсний дараа, мөн оны өвөл Тангудын томоохон хот болох Линчжоу /odoogийн Нинся хотонгийн өөртөө засах орны Линьву хотын баруун өмнө талд оршиж байсан эртний хот/-г эзэлж, "цэргийн жанжин нар хөвгүүд охид, хөрөнгө зоосыг булаацалдан авч байсан бол Елюй Чуцай гүн ердөө л хэдэн боть ном судар, хоёр тэмээ ачаатай тэнцэх хэмжээний гишүүнэ авчээ. Хожим цэргүүдийн дунд өвчин тархаж, зөвхөн тэр гишүүнэ л хэрэг болж хэдэн түмэн хүний амийг аврав" хэмээн ном, сурвалж бичиг зэрэгт тэмдэглэжээ.³¹ Линчжоу хотыг эзэлсний дараа монголын цэрэг Тангудын нийслэл Чжунсинфу-г /odoogийн Нинся хотонгийн өөртөө засах орны төв Инчуан хот/ 1227 оны долоон сард эзэлснээр Тангудын Сися улс мөхжээ.³² Елюй Чуцай монголын их цэрэгтэй хамт 1227 оны есөн сард Монгол нутагт буцаж иржээ.³³

Елюй Чуцай Чингис хааны баруун зүгийн буюу Дундад Азийн орнуудыг байлдан дагуулах аян дайнд дагалдан явахад түүний эрх үүрэг төдий л их биш, тэрээр хэдийгээр Чингис хааны дэргэд алба хааж байсан боловч хаан түүний чухал албан тушаалд тавьж ажиллуулаагүй, зөвхөн бичиг баримтын төсөл боловсруулах болон байгалийн үзэгдэл, тухайлбал, зуны цагт цас орох, өвлийн

цагт тэнгэр дугарах, мөн нар, сар хиртэх зэрэг байгалийн үзэгдлийн учир шалтгааныг тайлбарлахад л ашиглаж байсан.³⁴ Елюй Чуцай Дундад Азид алба хашиж байсан 10 орчим жилийн хугацаандaa хамгийн өндөр албан тушаалд томилогдсон нь 1222 онд Тараз хотын Газар тариалангийн хэрэг эрхэлсэн түшмэлээр томилогдсон /энэхүү албан тушаалд томилогдохоос өмнө Елюй Чуцай 1220-1222 онд Самарканд хотын захирагчийн туслах байсан/ явдал байлаа.³⁵ Чингис хаан заримдаа Елюй Чуцайгаар мэргэ төлгө үйлдүүлж байсан тухай түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн байdag.³⁶ Чингис хаан дайн байлдаанд мордохынхоо өмнө заавал мэргэлүүлдэг байсан бөгөөд тэрээр бусдаар мэргэлүүлсэнийг өөрийнхөө мэргэлсэнтэй тохирч буй эсэхийг шалгадаг зурсилтай байлаа.³⁷

Дундад Азийн орнуудыг байлдан дагуулах үед Чингис хаан Елюй Чуцайг өндөр албан тушаалд тавьж ажиллуулаагүй байсан шалтгаан нь дор дурдсан зүйлтэй холбоотой байсан болов уу. Дундад Азийн орнуудын байгалийн нөхцөл, үйлдвэрлэлийн харилцаа, ард иргэдийн ухамсар, дадал заншил зэрэг нь цөм Елюй Чуцайн төрж өссөн газар нутгийнхаас тэс өөр байсан учраас тэдгээр орныг Елюй Чуцайн баримталж байсан "Күнзийн сургаалаар улс орныг ноёрхон захирах" онол, арга замаар үнэхээр захирч болохгүй байсан билээ. Ийм ч учраас Елюй Чуцайн "Күнзийн сургаалаар улс орныг ноёрхон захирах" талаар гаргасан удаа дараагийн санал зөвлөгөөг Чингис хаан хүлээж авсангүй. Энэ талаар Елюй Чуцай "Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл" зохиолдоо нэг бус удаа дурдан бичжээ.³⁸ Чингис хааны дэргэд 10 орчим жил алба хаахдаа /1218-1227/ эрх үүрэг нь төдий л их биш байсанд Елюй Чуцайн сэтгэл хангалуун бус байснаа ном зохиолдоо олон удаа илэрхийлжээ.³⁹ Гэвч чухал албанд тавиагүй хэмээн Елюй Чуцай сэтгэл санаагаар унаж гутарсангүй, харин ч түүний эрдэм мэдлэг, мэргэн ухааныг үнэлэн хэзээ нэгэн цагт улс орныг удирдан захирах төрийн том байгууллагад ажиллуулна гэж яматт итгэж байсан бодол санаагаа илэрхийлсэн шүлгүүд "Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл"-д цөөнгүй байсан билээ.⁴⁰

Чингис хаан хэдийгээр Елюй Чуцайг тухайн үед өндөр албанд тавьж ажиллуулаагүй боловч Дундад Азийн орнуудыг байлдан дагуулах аян дайнд олон жил хамт явсан учир их мэдлэг боловсролтой хүн болохыг сайн мэдэж, тохиромжтой цагт түүнийг өндөр албанд дэвшүүлэн ажиллуулах хэрэгтэй гэж бодож байлаа. Иймээс ч Чингис хаан, хөвгүүн Өгэдэйд захиж хэлэхдээ, "Энэ хүнийг тэнгэр бурхан бидэнд илгээсэн юм. Хойшид түүнийг төр болон цэргийн хэрэгт оролцуулах ёстой" хэмээжээ.⁴¹ Дээр дурдсан зүйл нь Өгэдэй хааны үед Елюй Чуцай Их Монгол улсын төрд өндөр тушаалын алба хашихад чухал үүрэг гүйцэтгэж, түүний амьдралд эргэлт гарахад зохих нөлөө үзүүлжээ.

1229 онд Өгэдэй их хаанд өргөмжлөгдөхөд Елюй Чуцай зохих үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Өгэдэй, Тулуй нар түүний зөвлөсөн бүхнийг сонсон, ёсоор болгож байсан нь⁴² Монголын хаад ноёд Елюй Чуцайг их хүндэтгэн итгэдэг, тэдэнтэй дотно сайн харилцаатай байсныг харуулжээ.

Чингис хааны үед Елюй Чуцайн албан тушаал төдий л өндөр биш байсан нь байлдан дагуулалын тэр цагт "зөөлнөөр номхотгох" бодлогыг баримтлагч бичгийн хүн Елюй Чуцайн хэрэгцээ тийм ч их байсангүйтэй холбоотой болов уу. Харин Өгэдэйн үед байлдан дагуулалыг үргэлжлүүлэн явуулахын хамт нэгэнт эзэлсэн улс орнуудад ноёрхолоо бэхжүүлэхийн тулд Елюй Чуцай мэтийн бичгийн хүн, эрдэмтэн мэргэд, янз бурийн мэргэжилтнийг төрийн албанд татан ашиглах шаардлага гарсан байна.⁴³ Өгэдэй хаан цагаагчин туулай жилд буюу 1231 онд Засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамыг байгуулжээ.⁴⁴ Елюй Чуцай, Өгэдэй хааны хооронд дотно харилцаатай байсан хийгээд Елюй Чуцайн мэдлэг боловсролыг ашиглах зорилгоор Өгэдэй хаан түүнийг Засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамыг ерөнхий сайдаар томилжээ.⁴⁵ Елюй Чуцай тэр цагаас хойш Монголын төрд өндөр албан тушаал эзлэх болжээ. Баядай тэргүүтэй

Өгэдэй хааны шадар ноёд эзэлсэн умард Хятадын ард иргэдийг нутгаас нь зайлуулан, хот балгасыг нь нураан, газар тариалангийн талбайг малын билчээр болгохыг Өгэдэй хаанд айлтган хүсчээ.⁴⁶ Гэтэл Баядай нарын саналыг няцаан эсэргүүцэж, Елюй Чуцай Өгэдэй хаанд айлтгахдаа, өмнө зүгийг байлдан аваахдаа эрхэм хаан танд үлэмж хэмжээний мөнгө зоос, эд хөрөнгө шаардагдах бөгөөд үүнийг хангахын тулд эзэлсэн умард Хятадын газар нутагт татавр гувчуурын хууль дүрэм тогтоож, тэр нутгийн тариалангийн ургацаас болон архи, давс мэтийн худалдааны зүйлээс татвар авч болохоос гадна, мөн темер хайлуулсан, уул усыг ашигласны татвар гэж авах хэрэгтэй. Дээр дурдсан бүх татварыг нийлүүлвэл, жилд 50 түмэн лан цагаан мөнгө, 8 түмэн хуй торго, 40 гаруй түмэн дань /нэг дань нь 103,54 кг-тай тэнцэн/ тариа будааг татварт авч болох ба энэ нь бидний хэрэгцээнд хангалттай юм. Иймээс эзлэгдсэн хятадын газар нутгийн ард иргэд манай улсад хэрэггүй хэмээн хэлж болохгүй гэжээ.⁴⁷ Өгэдэй хааны зөвшөөрснөөр Елюй Чуцай Яньцзин зэрэг 10 замд /зам-тухайн үеийн засаг захиргааны нэгж байсан/ татвар гувчуур хураах тусгай албыг байгуулж, орон нутагт нөлөө бүхий хятад хүмүүсийг тэдгээр албадын эрхлэгчээр томилжээ. Цагаагчин туулай жилийн /1231 оны/ намар Өгэдэйг Юнчжун /одоогийн БНХАУ-ын Шаньси мужийн Датун хот/-д хүрэлцэн ирэхэд нь Елюй Чуцай хураасан татвар гувчуурын данс бүртгэлийг түүнд үзүүлэхэд Өгэдэй хаан: "Чи ямагт миний хажууд байсан мөртөө ийм үлэмж хэмжээний тариа будаа, мөнгө зоосыг хэдийд яаж цуглувулж амжсан юм бэ ?" хэмээн хэлээд, тэр өдөртөө л Елюй Чуцайг Засгийн хэргийг өрөнхийлөн шийтгэх яамны сайдар томилсон тухай "Юан улсын судар"-ын Елюй Чуцайн шастирт тэмдэглэжээ.⁴⁸

Хэрэв тухайн үед Елюй Чуцай мэтийн өндөр албан тушаалтай ордны түшмэл эзлэгдсэн умард Хятадын нутаг газарт татвар гувчуур хураах тухай хууль дүрэм боловсруулан тогтоосноор улсын санд үлэмж хэмжээний мөнгө хөрөнгө оруулж болох талаар Өгэдэй хаанд ул үндэстэй тайлбартай ойлгуулж чадаагүй, Өгэдэй хаан шадар ноён Баядай нарын саналыг хүлээн авч, умард Хятадын ард иргэдийг нутгаас нь зайлуулан, газар тариалангийн талбайг малын билчээр болгосон бол тус газар нутгийн нийгмийн үйлдвэрлэл, хөгжлийг ихээхэн хойшоо ухраахаас гадна, үй түмэн хятад хүнийг орох гэр оронгуй, эрхлэх ажил төрөлгүй болгохоор зогсохгүй, тэдний зарим нь шивэгчин боол болж, зарим нь амь наасаа ч алдах байсан билээ.

Өгэдэй хааны анхдугаар онд буюу 1229 онд хааны ордны ноёд түшмэдийн эрх мэдлийг хязгаарлахын тулд Елюй Чуцай "Арван найман зүйт гүйцэтгэвэл зохих хэрэг" хэмээх журмыг боловсруулан гаргаж, дараа жилээс нь эхлэн мөрдөн хэрэгжүүлжээ. Уг журамд заахдаа, захирагч ноёдын эрхийг тэнцүүлэн тэдний эрх мэдлээ ашиглан дураар аашлах явдлыг хязгаарлахын тулд орон нутгийн цзонь /цзонь-тухайн үеийн засаг захиргааны нэгж байсан/ болгонд захиргааны хэрэг эрхэлсэн захирагч ноён, цэргийн хэрэг эрхэлсэн түмтийн ноён хэмээн тус тус томилсон байвал зохино., Дээд газрын зарлиг шийдвэрлгүйгээр сянь, чжоугийн /сян, чжоу-тухайн үеийн засаг захиргааны нэгж байсан/ захирагч ноёд дур мэдэж ард иргэдээс татвар гувчуур хураасан байвал, тэдгээр захирагч ноёдыг хуулиар шийтгэнэ., Монгол, уйгур зэрэг хүмүүсээс газар тариалангийн татвар төлөхөөс татгалзсан хүн гарвал, түүнийг цаазаар авна., Цаазаар авах ёстой ялтыг цаазлахад хаанд айлтгасны дараа сая ёсоор гүйцэтгэж болно ... хэмээжээ.⁴⁹

"Арван найман зүйт гүйцэтгэвэл зохих хэрэг"-т "цаазаар авах ёстой ялтыг цаазлахад хаанд айлтгасны дараа сая ёсоор гүйцэтгэж болно" хэмээн заасан нь үнэн хэрэгтээ эзлэгдсэн газар нутгийн хятад ноёрхочид, газрын эзэд дур зоргоороо боол шивэгчин, хамжлагатаа алан хядаж байсныг хязгаарлан зогсоож, энгийн номхон ард иргэдийн амь насыг хамгаалсан хууль болжээ. "Арван найман зүйт гүйцэтгэвэл зохих хэрэг" нь чухамдаа эзэлсэн умард Хятадын засаг захиргаа, цэргийг захирах, шүүх цааз, санхүү эдийн засгийн бүх

эрхийг нэгэн зэрэг эдэлж байсан хятад ноёрхогчдын эрх мэдлийг хязгаарлан, Өгэдэй хааны төвлөрсөн засаг төрийг бэхжүүлэх зорилготой байсан билээ.

Өгэдэй хаан, Елюй Чуцайн зөвлөсний дагуу, эзэлсэн умард Хятад орноос татварлах алба гувчуурын хэмжээг хятадын хүн амаас өрхөөр бодож авах журмыг тогтоожээ.⁵⁰ Албаны хэмжээ нь улсын санд зориулж хоёр ерх тутмаас нэг жин мяндас /нэг жин нь 0,5 кг-тай тэнцэнэ/, ноён, ван гүн нарын хэрэгцээнд зориулж таван өрх тутмаас нэг жин мяндас тус тус хураахаар тогтоож, газрын татварын хувьд гэвэл, сайн тарианы му /нэг му нь 0,06 гектартай тэнцэнэ/ тутмаас гурван шэн тариа /нэг шэн нь 1,035 кг-тай тэнцэнэ/, дунд тарианы му тутмаас хоёр шэн тариа, ус оруулсан сайн тарианы му тутмаас таван шэн тариа тус тус авахаар тогтоосон. Худалдааны зүйлээс татвар хураахдаа орлогын 30 хувийн нэгийг авах, давсны 40 жин тутмаас нэг лан цагаан мөнгө хураахаар тогтоожээ.⁵¹

Өгэдэй хаан эзлэгдсэн хятадын газар нутгийн ард иргэдээс дээр дурдсан олон төрлийн татвар гувчуур авахын зэрэгцээ Монгол ард олноос ч мөн алба татвар авдаг байв. Тухайлбал, 1229 онд гаргасан хааны санд хураах улсын нэгдсэн албан татварын хуулиар Монголын хаан харьяат монгол хүний адuu, үхэр, хонь тус бүр зуун толгой тутмаас нийгээд морь, үхэр, хонийг татварлан авах журам тогтоожээ.⁵²

Монголын хаад хятадын газар нутагт слон жил байлдан дагуулах дайн явуулж, олон тооны ард ирэдийг монголын ван гүн, ноёдын болон хятадын ноёрхогч, газрын эздийн боол шивэгчин болгосон явдал нь тус газар нутгийн нийгмийн үйлдвэрлэлийн хөгжилд нэлээд их саад тогтор учруулжээ. Өгэдэй хааны үед энэхүү байдал өөрчлөгдөж монгол, хятадын ноёрхогчдын захиргаан дор байсан олон тооны боол шивэгчин буюу үйлдвэрлэх хүч хувь хүний дарлал мөлжлөгөөс ангижран гарч, Монгол гурний харьяат иргэн болж, нийгмийн үйлдвэрлэлд оролцох болсон ба үүнд Елюй Чуцай нэлээд их үүрэг гүйцэтгэсэн билээ.

Улаан бичин жилийн /1237 оны/ намар Худуху ноён хүн амын тооллогын бүртгэлийг хааны ордонд авчирч, Өгэдэй хаанд үзүүлэхэд нь тэрээр уламжлалт ёсыг даган эзэлсэн газар нутгийг хүн амтай нь хамт гавьяатай сайд ноёдод хувааж өгвөл зохино хэмээн айлтгажээ. Елюй Чуцай үүнийг эсэргүүцэн татгалзаж, “газар нутгийг хүн амтай нь сайд ноёдод хувааж өгдөг нь сайд ноёдын хооронд зөрчил маргааныг үүсгэх эх үүсвэр юм. Үүнээс сэргийлэн болгоомжлохын тулд тэдэнд газар нутгийг хүн амтай нь өгөх биш, харин ахиу хэмжээний алт, торго зэрэг эд зүйлс тэдэнд өгөх хэрэгтэй” хэмээн айлтгахад Өгэдэй хаан: “Би тэдэнд газар нутаг хүн амтай хувааж өгнө гэж нэгэнт амалсан хойно, одоо яах вэ?” гэж хэлэхэд нь Елюй Чуцай: “Тэгвэл, хааны ордоос татвар гувчуур хураах тусгай түшмэдийг томилон, тэдгээр газар нутгийн ард иргэдээс авбал зохих татварыг хураан авч, жилийн эцэст хураасан татварыг сайд ноёдод өгч болно. Харин эзэмшлийн газраасаа дур мэдэж татвар гувчуур хураах эрх тэдэнд олгохгүй байх хэрэгтэй” хэмээн зөвлөлжээ.⁵³ Өгэдэй хаан, Елюй Чуцайн дэвшүүлсэн саналыг хүлээн авч ард иргэдээс авах татвар гувчуурын төрөл, хэмжээг тогтоожээ.⁵⁴

Елүй Чуцай Дундад Азийн худалдаачдын их хүүгээр мэнгэ хүүлэх аргаар ард иргэдийг дарлан мөлжиж байсан явдлыг эрс эсэргүүцэж байсан. Өгэдэй хааны үед Дундад Азийн том худалдаачид Монгол оронд олноор ирж, монголын язгууртан ноёдын ивээл тусламжтайгаар асар их ашиг хонжоо олж байжээ. Дундад Азийн худалдаачдын ашиг хонжоо олох арга хэлбэрийн нэг нь их хүүтэй зээл олгох явдал байсан бөгөөд тэдгээр мэнгэ хүүлэгчид “хурган хүү” буюу жил бүрийн хүүг өмнөх жилийнхээс хоёр дахин их байхаар бодож ард иргэдэд зээл олгож байлаа.⁵⁵ Энэхүү өндөр хүүтэй зээлээс болж мянга түмэн ард иргэд ядууран хоосорч, зарим нь эхнэр хүүхдээ бусдад боол шивэгчин болгож

худалдсан ч өрөө дарж чадахгүйд хүрчээ. Елюй Чуцай дээрх байдлыг Өгэдэй хаанд айлтган танилцуулж, хааны зөвшөөрлөөр улсын сангаас нийт 76 мянган дин /нэг дин нь 5 буюу 10 лантай тэнцэнэ/ цагаан мөнгө гаргуулан, ард иргэдийн өмнөөс бүх өрийг дарсанаар олон мянган хүнийг Дундад Азийн худалдаачдын их хүүгээр мөнгө хүүлэх дарлал мөлжлөгөөс чөлөөлжээ.⁵⁶ Елюй Чуцай Өгэдэй хаанд мөн айлтгаж, хойшид зээл олгосон хугацааг үл харгалзан, зээлийн хүүг уг зээлийн хэмжээнээс хэтрүүлж болохгүй хэмээх журам товоо талаар зөвлөснийг Өгэдэй хаан хүлээн авчээ.⁵⁷ Өгэдэй хааны тогтоосон энэхүү журам нь хожим Юан улсын хууль цаазын нэгэн зүйл болон оржээ.⁵⁸

Елюй Чуцай өртөөний асуудлыг эмх журамтай болгох талаар Өгэдэй хаанд зөвлөж байлаа. Жишээлбэл, гэрэгэ, зар бичиггүй бол өртөөгөөр явахыг хориглож, өртөөгөөр явагчдад олгох хоол хүнсний хэмжээг тогтоож байхыг зөвлөсөн нь Монголын сайд ноёдын дур зоргоор улаа барьж, элч нарыг хамаагүй газар орноор хэсүүчлэн давхих явдлыг болиулж, энгийн малчин ардад учруулж байсан үлээмжхэн зовлон чирэгдлийг зогсоожээ.⁵⁹

Өгэдэй хаан төрийн эрхийг барьж байсан үед өмнө нь байн байн боогдон хаагдаж, тасалдаж байсан дорно, өрнийн орнуудын хоорондоо харилцах худалдааны зам сэргээн нээгдэж, хятад, Дундад Азийн худалдаачид Монгол оронд олноор ирэх болж, асар их ашиг хонжоо олж байлаа. Өгэдэй хааны ордонд олон газрын худалдаачид, ялангуяа Дундад Азийн худалдаачид ирж байсан ба тэднийг Өгэдэй хаан онцгой дотночлон үзэж элдвээр тэтгэн дэмжиж байжээ. Өгэдэй хааны сүүлийн жилүүдэд Дундад Азийн худалдаачдын нелөө улам бүр нэмэгдсээр Елюй Чуцай болон хятад зүгийн сайд түшмэдийн эрх хүчийг буруулав. Тухайлбал, 1240 оны хаврын тэргүүн сард лалын худалдаачин Абдурхманыг эзлэгдсэн орнуудын олон мужаас татвар гувчуур хурааж авах сайдаар томилжээ.⁶⁰

Тэр үед Өгэдэй хааны хатан Туракина лалын худалдаачин нарыг мөн дотночлон, тэдэнд зүйл бүрээр тусалж байжээ. Ялангуяа, лалын худалдаачин Абдурхман, Туракина хатанд онцгой дотночлогдож тэр нь Туракина хатантай хуйвалдаж, хааны тамгыг хоосон цаасан дээр олноор даруулж, сүүлд хааны нэрээр зарлиг зохион бичиж, хааны өмнөөс дур мэдэн хэрэг шийддэг байлаа.⁶¹ Дээрх явдлыг Елюй Чуцай эрс эсэргүүцэж байгаагаа илэрхийлэн, учир байдлыг Туракина хатанд өөрийн биеэр айлтган тайлбарлаж байж сая уг явдлыг зогсоожээ.⁶²

Хятан угсааны язгууртан гаралтай Елюй Чуцай нь Чингис, Өгэдэй нарын хоёр хааны үед 30 шахам жил⁶³ Монголын төрд алба хашиж, ялангуяа Өгэдэй хаанд бүр ч дотночлогдож, түүний шадар сайд түшмэдийн нэг нь байлаа. Елюй Чуцай 1231 оноос Их Монгол улсын Засгийн хэргийг ерөнхийлэн шийтгэх яамны сайдаар томилогдон, эзэлсэн газар орнуудын цэргийн хэргээс бусад тухайлбал, алба гувчуур, эдийн засаг, улс төр, соёлын холбогдол бүхий бараг бүх хэрэг явдалд оролцжээ. Олон жилийн турш Өгэдэй хаан, Елюй Чуцайн боловсруулсан хууль дүрмийг үндсэнд нь сайшаан дэмжиж, Елюй Чуцайн саналын дагуу тэдгээр хууль дүрмийг эзэлсэн газар орнуудад хэрэгжүүлж байсан билээ. Елюй Чуцай эзэлсэн орнуудыг ялангуяа, Хятад орныг цаашид ноёлон захирах талаар Өгэдэй хаанд олон зүйлийн зөвлөлгөө өгсөний дотор “Хятад орныг хятадын хуулиар захирах” хэрэгтэй хэмээн зөвлөж, “морин дээрээс байгуулсан улсыг морин дээрээс жолоодож болохгүй” гэж хэлжээ.⁶⁴ Өгэдэй хаан 1218 оноос Монголын төрд алба хашиж байсан Елюй Чуцайн үгийг ихэд тоодог байсан боловч Монголын төр Хятадын төрийн засаг захиргааны ёсноос авч хэрэглэх гэсэн түүний саналыг хүлээн аваагүй билээ.

Өгэдэй хааны үед Монголын фөодал түшмэдийн нэг хэсэг ялангуяа, цэргийн эрхтэн жанжин нар нь суурин амьдрал, хот балгас, газар тариалангийн талбайг бусниулан, эзэлсэн орнуудыг ноёлон захирах нарийн төвөгтэй ажлаас

бэрхшээж, шинэ шинэ газар орнуудыг эзэлж, дээрэм тонуул хийхийг сонирхож байсан бол нөгөө хэсэг болох Елюй Чуцай мэтийн бичгийн түшмэд нь байлдан дагуулалыг үргэлжлүүлэн хийхийн хамт эзэлсэн орнуудыг удаан хугацаагаар өөртөө ашигтайгаар ноёлон захирах явдлыг чухалчилж байжээ.

Дээр дурдсанаас үзэхэд Монголын төрийн хэрэгт оролцож байсан зарим монгол ноёд түшмэд, Елюй Чуцай нарын хооронд үзэл бодлоор нэлээд зөрчилтэй байсан учир эзэлсэн газар орнуудыг ноёлон захирах талаар Елюй Чуцайн гаргасан зарим санал зөвлөлгөөг зөвхөн Өгэдэй хааны эхэн үед хэрэгжүүлж чадсан болохоос биш цаашид нэг их амжилт олоогүй юм. Гэвч энэ нь эзэлсэн газар орнуудыг ноёлон захирах талаар Монголын хаадын бодлого боловсруулахад болон тэдгээр газар нутгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд Елюй Чуцай зохих үүрэг гүйцэтгэж байсныг үнэлэхэд нөлөөлөхгүй билээ.

Abstract:

Yelu Ch'u-tsai was the descendant of the royal house of the Liao Empire of the Khitans. He was the close advisor first to Chinggis Khaan, and later to Chinggis' son and successor, Ogodey (Ugedey). Along with Chinggis, Yelu Ch'u-tsai took part in the Khwarasmian campaign in 1219-1227. He described his observations in *Xi-lu* ("Chronicles of the Western Journey") and *Zhangran Jiushi Wenji* ("Compilation of Pilgrim Zhangran's Diaries"). Yelu Ch'u-tsai was a witness of many historical events happened during the reign of Khaans Chinggis and Ogodey.

ТАЙЛБАР, ЗҮҮЛТ:

1. Юан улсын судар, 2, 146-р дэвтэр., Монголын нууц товчоо /хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав/, УБ., 1957, 95, 98, 101, 103-104 дэх тал., "Монголын түүхийн бага нэвтэрхий толь", 1-р боть, УБ., 1998, 173 дахь тал., "Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой" /академич Ш. Бира монгол, англи хэлээр оршил бичиж "Алтан товч"-ийн жинхэнэ эхийг гэрэл зургийн аргаар Улаанбаатарт 1990 онд хэвлүүлэв/, 45, 47, 48, 50, 78, 84 дэх тал., Ван Говэй. Елюй Вэньчжэн гүнгийн он дараалалын бичиг /Елюй Вэньчжэн гүн няньпу/.
2. Юан улсын судар, 146-р дэвтэр.
3. Мөн тэнд
4. Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр., Igor de Rachewiltz, Hok-lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W. Geier. In the service of the khan, Eminent personalities of the Early Mongol-Yuan period /1200-1300/, Harrassowitz Verlag-Wiesbaden, 1993, p. 139-140.
5. Монгол улсын түүх, дэд боть, УБ., 2003, 117, 135, 139, 142, 147, 186, 189., Юан улсын судар, 146-р дэвтэр.
6. Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
7. Юан улсын судар, 146-р дэвтэр.
8. Мөн тэнд
9. Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
10. Була хот нь одоогийн СУӨЗО-ны Эби нуурын баруун талд орших Бор хошууны нутаг дэвсгэр дээр оршиж байсан бөгөөд тухайн үед дорно өрнийн харилцааны чухал зангилаа газар байлаа.
11. Борохоро нуруу нь Тэнгэр уулсын нэг нуруу бөгөөд 250 км урт, 4359 метр өндөр, олон мөсөн голтой, уулт хээр, гацууран ой, нугатай.
12. Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
13. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, УБ., 1995, 131 дэх тал., Рашид-ад-Дин. Сборник летописей, т.1, кн.2, М-Л, 1952, стр. 182, 198., Хятадын түүхийн их толь бичиг /Чжуанго лиши да цыдяны/, Шанхай, 1986, 260 дахь тал.
14. Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
15. The History of the world-conqueror by Ala-al-Din`Ata-Malik Juvani, translation from the text of M.M.Qazvini by J.A.Boyle, Manchester University press, 1958, v.1, p.103; Рашид-ад-Дин. Сборник летописей, т.1, кн.2, М-Л, 1952, стр. 205.
16. Рашид-ад-Дин. Сборник летописей, т.1, кн.2, М-Л, 1952, стр. 205.
17. Мөн ном, стр. 207-209.
18. Ли Чжичан. Чанчунь бомбын баруун газар зорчсон тэмдэглэл /Чанчунь чжэньжэнь сиоу цзи/. Ли Чжичан нь 1193-1256 оны хооронд амьдарч байсан. Чанчунь бомбын итгэлт шавь байсан бөгөөд Чанчунь бомбо Чингис хаантай уулзахад тэрээр ямагт дэргэд нь байжээ., Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанъжань цзюйши вэньцзи/, 6-р дэвтэр.
19. Рашид-ад-Дин. Сборник летописей т.1, кн.2, М-Л, 1952, стр.214-216.
20. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанъжань цзюйши вэньцзи/, 12-р дэвтэр., Хятадын түүхийн их толь бичиг /Чжуанго лиши да цыдяны/, Шанхай, 1986, 296 дахь тал. Елюй Ахай-хятан угсааны хүн бөгөөд Чингис хааны шадар сайдуудын нэг, Тангудын Сися улстай байлдахад цэргийн их гавьяя байгуулсаныг өндөрөөр үнэлэн түүнийг 1214 онд хааны зарилгаар "тайш" хэмээх албан тушаалд дэвшүүлэн ажиллуулжээ.

21. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанъянь цзюйши вэньцзи/, 12-р дэвтэр., Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
22. Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
23. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанъянь цзюйши вэньцзи/, 8-р дэвтэр., Igor de Rachewiltz, Hok-lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W. Geier. In the service of the khan, Eminent personalities of the Early Mongol-Yuan period /1200-1300/, Harrassowitz Verlag-Wiesbaden, 1993, p. 146-147.
24. Мөн ном, 2,5,6-р дэвтэр.
25. Мөн ном, 5-р дэвтэр.
26. Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр.
27. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966, 238 дахь тал., Рашид-ад-Дин. Сборник летописей т.1, кн.2,М-Л, 1952, стр. 226.
28. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанъянь цзюйши вэньцзи/, 8-р дэвтэр., Рашид-ад-Дин. Сборник летописей т.1, кн.,М-Л, 1952, стр. 148-149.
29. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966, 239 дэх тал., Ч.Далай. Монголын түүх, Их Монгол улс /1206-1260/ дэд дэвтэр, УБ., 1994, 110 дахь тал.
30. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанъянь цзюйши вэньцзи/, 13-р дэвтэр.
31. Igor de Rachewiltz, Hok-lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W. Geier. In the service of the khan, Eminent personalities of the Early Mongol-Yuan period /1200-1300/, Harrassowitz Verlag-Wiesbaden, 1993, p. 146-147., Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Гочао вэньлэй/, 57-р дэвтэр. Су Тяньцзюе нь 1294-1325 оны хооронд амьдарч байсан. Тэрээр Юан улсын төрд алба хашиж байгаад Тогоонтемер хааны үед 1352 онд Улаан алчууртны бослогыг дараахад дайчлагдаж, дайн байлдааны явцад евчинеэр нас барсан. Түүний эцэг Су Чжидао /1261-1320/ Их Монгол улсын төрд мөн алба хашиж байсан., А. Дамдинсүрэн. Монголын цэргийн товч түүх, УБ., 1990, 121 дэх тал.
32. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966, 239 дэх тал., Хятад улсын нэвтэрхий түүх /Чжунго тунши/, 6-р дэвтэр, Бээжин, 1997, 199 дэх тал.
33. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанъянь цзюйши вэньцзи/, 3-р дэвтэр.
34. Юан улсын судар, 146-р дэвтэр., Сун Цзычжэнь. Төв бичгийн яамны сайд Елюй гүнгийн булшин дээрх гэрэлт хөшөөний бичээс /Чжуншулин Елюй гүн шэньдао бэй/. Сун Цзычжэнь нь 1185-1266 оны хооронд амьдарч байсан. Тэрээр 1235-1265 оны хооронд Их Монгол улсын төрд алба хашиж байжээ. Н.Ц.Мункуев. Китайский источник о первых монгольских ханах, Москва, 1965, стр.15.
35. Елюй Чуцай. Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр.
36. Юан улсын судар, 146-р дэвтэр.
37. Мөн тэнд
38. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанъянь цзюйши вэньцзи/, 3, 11-р дэвтэр.
39. Мөн зохиол. 2,3-р дэвтэр.
40. Мөн зохиол. 3,4-р дэвтэр.
41. Юан улсын судар, 146-р дэвтэр.
42. Монгол улсын түүх, дэд боть, УБ., 2003, 139 дэх тал., Ч. Далай. Монголын түүх /Их Монгол улс/, дэд дэвтэр, УБ., 1994, 130 дахь тал., Юан улсын судар, 146-р дэвтэр., Сун Цзычжэнь. Төв бичгийн яамны сайд Елюй гүнгийн булшин дээрх гэрэлт хөшөөний бичээс /Чжуншулин Елюй гүн шэньдао бэй/.
43. Юан улсын судар, 88-р дэвтэр.

44. Юан улсын судар, 2-р дэвтэр., Монголын түүхийн бага нэвтэрхий толь, 1-р боть, УБ., 1998, 174 дахь тал.
45. Монгол улсын түүх, дэд боть, УБ., 2003, 142 дахь тал., Юан улсын судар, 2-р дэвтэр., Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 4-р дэвтэр.
46. Юан улсын судар, 9-р дэвтэр., Ту Цзи. Монголын түүхийн тэмдэглэл /Мэн-у-эр шицзи/, Бээжин, 1984, 362 дахь тал., Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч /Юаньчао миньчэнь шилюе/, Шанхай, 1936, 59-60 дахь тал.
47. Юан улсын судар, 146-р дэвтэр., Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч /Юаньчао миньчэнь шилюе/, Шанхай, 1936, 60 дахь тал.
48. Юан улсын судар, 146-р дэвтэр., Hsiao Ch'i-ch'ing. New studies in Mongol-Yuan history., Tapei, 1994, p.81.
49. Юан улсын судар, 146-р дэвтэр.
50. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ., 1966, 258 дахь тал.
51. Юан улсын судар, 146-р дэвтэр, Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч /Юаньчао миньчэнь шилюе/, Шанхай, 1936, 63 дахь тал.
52. Н.Ц. Мункуев. "Об экономическом положении Монголии и Китая", Краткие сообщения института народов Азии, 1965, № 76, стр. 138., Юан улсын судар, 2-р дэвтэр.
53. Юан улсын судар, 2, 95, 146-р дэвтэр.
54. Мөн тэнд
55. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ., 1966, 259 дахь тал., Сун Цзычжэнь. Төв бичгийн яамны сайд Елюй гүнгийн булшин дээрх гэрэлт хөшөөний бичээс /Чжуншулин Елюй гүн шэнъдаа бэй/.
56. Юан улсын судар, 2, 146, 155-р дэвтэр., Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч /Юаньчао миньчэнь шилюе/, Шанхай, 1936, 63 дахь тал.
57. Мөн тэнд
58. Юан улсын судар, 105-р дэвтэр.
59. Монгол улсын түүх, дэд боть, УБ., 2003, 148 дахь тал., Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч /Юаньчао миньчэнь шилюе/, Шанхай, 1936, 64 дахь тал.
60. Юан улсын судар, 2-р дэвтэр.
61. Юан улсын судар, 146-р дэвтэр.
62. Мөн тэнд
63. Мөн тэнд
64. Монгол улсын түүх, дэд боть, 2003, 245 дахь тал., Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч /Юаньчао миньчэнь шилюе/, Шанхай, 1936, 60 дахь тал.